



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/5/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2019 он

Тэргүүлэх аудитор:

Ч.Ариунаа

Утас: 7052-2734

Цахим хаяг: dornogovi@audit.gov.com

Аудитын менежер:

Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020

Цахим хаяг:

Аудитор:

Б.Байгал

Утас:

Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	6
2.1	Оршил	6
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	7
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	7
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	8
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	9
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	9
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	14
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	14
2.11	Шилэн дансны мэдээлэл	15
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	15
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	15
3	Менежментийн захидал	16
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,

Утас: (705) 2-27-34

2019.02.27 № 1-6/239

танай _____-ны № _____-т

ЧАНДМАНЬ-БАДРАЛ ОНӨХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
У.САНРАЙЖАВ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж Чандмань-Бадрал ОНӨХХК-ны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чандмань-Бадрал ОНӨХХК-ны 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

444190244

Аудитын гол асуудал

1. 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлэн мөнгө юаны үлдэгдэл болох 7362 408.60 төгрөг бэлнээр байхгүй дутагдсан байх тул А.Мөнхтуяа касс 3,594,946.31 төгрөг, Б.Сарангоо 3767462,29 төгрөгийг тус тус төлж барагдуулах төлбөрийн акт хүргүүлсэн.
2. Тухайн байгууллагад нийт 5 төрлийн 20 нэгж авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглагдаж байгаа боловч Авто тээврийн үндэсний төвөөс авсан мэдээ болон тээврийн хэрэгслийн гэрчилгээнээс харахад 9 тээврийн хэрэгсэл тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй, 4 тээврийн хэрэгсэл нь Замын-Үүд сумын НААҮОНӨХХК-нд, 1 тээврийн хэрэгсэл Замын-Үүд сумын ЗААЛбанд бүртгэлтэй, зарим тээврийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй байна.
3. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 828.5 мянган төгрөг төлсөн хэдий ч 2018 оны турш татварын байгууллагад тайлан илгээгээгүй, тайлагнаагүй байна
4. Нийт 1.036.992.0 мянган төгрөгийн худалдан авалтын хийхдээ шууд гэрээ байгуулан хийсэн
5. Бэлэн мөнгийг их хэмжээгээр харилцах данснаас чекээр гарган авч шууд худалдан авалт хийсэн, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүй, тооцоог сар бүр бодоогүй, эд хариуцагч тайлангаа гаргаж сураагүй байдлаас үүдэн мөнгөн кассаар ажиллаж байсан А.Мөнхтуяагийн нэр дээр 12,529,308.63 төгрөгийн, Б.Сарангоогийн нэр дээр 6,589,509.03 төгрөг нийт 19,118,817.66 төгрөгийг дараа тооцооны авлага бүртгэж, тооцоог бодоогүй байна.
6. Тус байгууллага тайлант онд нийт 679,884.8 мянган төгрөгийг харилцах данснаас бэлнээр авч Эрэн хотоос бараа түүхий эд материалыг шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн байна.
7. Зарцуулсан бэлэн мөнгөний зарцуулалтаас нийт 26531.4 мянган төгрөг эрсдэлд орж өр дутагдал болж тодорхойгүй байдалд орсон, кассын үйл ажиллагааны журам байхгүй, мөнгөн хөрөнгө их хэмжээгээр касс дээр олон хоногоор хадгалагдаж байгаад хяналт хийдэггүй, бэлэн мөнгө хадгалах, хамгаалах аюулгүй ажиллагааны нөхцөл бүрдээгүй байна.
8. Кассын ажилтан, кассын тайланг хийж хэвшээгүй, хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахдаа буруу бичилт хийсэн, анхан шатны нотлох баримтад И баримт хавсаргаагүй, хүчин төгөлдөр бус баримтууд хавсаргасан байна.
9. Бэлэн мөнгөөр бараа бүтээгдэхүүн авахдаа үнийн судалгааг хийдэггүй, захиалгын хуудас тодорхой бичигдээгүй баталгаажуулаагүй, нэгжийн өртгийг хянах боломжгүй, солигдох бараа бүтээгдэхүүнд дахин хил гаалийн бүрдүүлэлт хийхэд татвар төлж илүү зардал гарах барааны өртгийг хий өсөх эрсдэлтэй байна.
10. Бэлэн мөнгөний худалдан авалттай уялдан, санхүү бүртгэлийн хяналтгүй байдал нэмэгдсэн, хууль журам зөрчигдсөн, мөнгөн хөрөнгө ашиглах завших боломжийг бүрдүүлсэн, ашиглахгүй бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн, орон нутгийн үйлдвэр эрхлэгчийг дэмжих боломж хязгаарлагдсан зэрэг олон сөрөг үр дагавар гарсан тул бэлэн мөнгөний кассын үйл ажиллагааг зогсоож жижиг мөнгөн санг ажиллуулж, бараа бүтээгдэхүүн худалдан авах үйл ажиллагааг

хуульд нийцүүлэн гэрээ байгуулж,бэлэн бус шилжүүлгээр гүйцэтгэх шаардлагатай.

Нийт 1057785,3 мянган төгрөгийн ажил гүйлгээний зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, хэмжилт, иж бүрэн байх, гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Чандмань-Бадрал ОНӨХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг У.Санрайжав-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.22-ноос 2019.02.26-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын хариуцаж хэрэгжүүлэв.

Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.15-ны өдрийн 1/75 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Чандмань-Бадрал ОНӨХХК талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Чандмань-Бадрал ОНӨХХК нь Бид дулаан болон усыг хамгийн бага зардлаар үйлдвэрлэж, хэрэглэгчдэд нийлүүлэх, бохир усыг татан зайлуулах ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн ИТХ-ийн шийдвэрээр Чандмань-Бадрал ОНӨХХК үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын аж ахуй нэгж байгууллага, орон сууцны ахуйн хэрэглээний дулааны эрчим хүч, хэрэглээний халуун хүйтэн ус, стандартын шаардлага хангасан ундны цэвэр усаар хангах, бохир ус зайлуулахтай холбоотой ажил үйлчилгээ үзүүлэх болон эдгээртэй холбоотой барилга байгууламж, шугам, сүлжээ, машин тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг бүрэн хариуцан ажиллана.

Чандмань-Бадрал ОНӨХХК үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Чандмань-Бадрал ОНӨХХК удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны №40 дүгээр тогтоол

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын ТУЗ өөрчлөн байгуулагдсан

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд (нийцсэн/нийцээгүй) байна.

Боловсруулсан бодлогын баримт бичиг хэт хураангуй, ойлгомжтой тайлбар хийгдээгүй байна.

Чандмань-Бадрал ОНӨХХК санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Чандмань-Бадрал ОНӨХХК санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Виница” програм хангамж ашигладаг байна.

Чандмань-Бадрал ОНӨХХК дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Чандмань-Бадрал ОНӨХХК бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнгээс 1 хувиар сонгов.

Нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны нийт орлогын дүн 3596445,2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 35964,4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн төвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 19 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 15 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	12	2,665,,328,7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	7,362.40	
3	Албан шаардлага өгсөн	4	1,056,989,5	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		17	3,729,680,6	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Их хэмжээний өндөр дүнтэй бэлэн мөнгөөр шууд худалдан авалт хийх, эд хариуцагчийн тайлан тооцоог бодож хяналт хийгээгүй, хяналт хийх чиг үүргийн албан тушаалтнууд өөрсдөө бэлэн мөнгөөр бараа материал худалдан авах ажилд оролцсон, бүртгэлээр тавих хяналт хаагдсан зэрэг нөхцөл байдал үүссэн байна.

Тус байгууллага бэлэн мөнгөний кассыг төгрөг болон юаны гэсэн 2 байдлаар нээсэн боловч тайлан тооцоог тухай бүрд нь гаргадаггүй, мөнгөн хөрөнгийг нэг хүн зарцуулдаггүй олон хүн бэлнээр авч Эрээн хот явж бараа татах ажилд зарцуулж тайлан гаргадаг байна.

Тайлант жилийн мөнгөн хөрөнгийн сарын дундаж үлдэгдэл 5,0 сая төгрөг зарим саруудад 10,0-30,0 сая төгрөгийн үлдэгдэл 5-20 хоног хадгалагдсан зэрэг нь мөнгөн хөрөнгө алдагдах эрсдэлтэй бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг дараа тооцооны авлага дансаар бүртгэж, тооцоо бодож, шийдвэрлэх хугацааг алдагдуулсан байна.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлэн мөнгө юаны үлдэгдэл болох 7362 408.60 төгрөг бэлнээр байхгүй дутагдсан байх тул А.Мөнхтуяа касс 3,594,946.31 төгрөг, Б.Сарангоо 3767462,29 төгрөгийг тус тус төлж барагдуулах төлбөрийн акт тавьж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.” 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Бэлэн мөнгөний кассаас дутагдсан 7,362,408.60 төгрөгийг хариуцсан холбогдох ажилтнуудаар төлүүлж төсвийн орлого болгож, Дорноговь аймгийн Төрийн сан дахь Бусад нэр заагдаагүй орлогын 100060000955 тоот дансанд төвлөрүүлэх Төлбөрийн актын биелэлтийг 2019 оны 03 дугаар сарын 25-ны дотор Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэхийг Гүйцэтгэх захирал У.Санрайжав, ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн нарт хариуцуулав.

2. Тухайн байгууллагад нийт 5 төрлийн 20 нэгж авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглагдаж байгаа боловч Авто тээврийн үндэсний төвөөс авсан мэдээ болон тээврийн хэрэгслийн гэрчилгээнээс харахад 9 тээврийн хэрэгсэл тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй, 4 тээврийн хэрэгсэл нь Замын-Үүд сумын НААҮОНӨХХК-нд, 1 тээврийн хэрэгсэл Замын-Үүд сумын ЗААлбанд бүртгэлтэй, зарим тээврийн хэрэгсэл нь тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй байна.

Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт 828.5 мянган төгрөг төлсөн хэдий ч 2018 оны турш татварын байгууллагад тайлан илгээгээгүй, тайлагнаагүй байна.

Энэ нь АТБӨЯХАТТХуулийн 3 дугаар зүйлд "монгол улсын нутаг дэвсгэрт авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшиж буй хувь хүн, аж ахуйн нэгж албан татвар төлөгч байна", 7.2-т "аж ахуйн нэгж байгууллага нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тайланг татварын албанд ирүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1."нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Үйл ажиллагаанд ашиглаж байгаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг гэрчилгээжүүлж өөрийн байгууллагын нэр дээр шилжүүлэн авах
2. Төсөвт төлөх татварыг үнэн зөв тодорхойлон татварын тайлан тухай бүр гаргаж тайлагнах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** ирүүлэхийг Гүйцэтгэх захирал У.Санрайжав, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн нарт даалгав.

3. 2018 онд тус байгууллага нь шатахуун, түлш, хөрөнгө оруулалт урсгал зардал, материал, хангамжийн зардал гэсэн 4 төрлийн худалдан авах ажиллагаанд 972.354.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж худалдан авах үйл ажиллагааг шууд худалдан авалтын аргаар зохион байгуулсан байна. Уг худалдан авалтыг нээлттэй тендер зарлан гүйцэтгэх ёстой байсан.

Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал, засвар үйлчилгээний зардал, гадаад үйлчилгээ гэсэн 3 төрлийн зардлын санхүүжилтэд 64.638.0 мянган төгрөгийн худалдан авалтыг зохион байгуулахдаа харьцуулалтын аргыг ашиглалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Тусгай зориулалттай тээврийн хэрэгсэл худалдан авахаар тендер зарласан боловч ТБОНӨХБАҮХАТХуульд заасан хугацааг зөрчин тендерийн нээлт хийх хугацаа болоогүй байхад худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Нийт 1.036.992.0 мянган төгрөгийн худалдан авалтын хийхдээ шууд гэрээ байгуулан хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, 8.4.Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно, Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан Цахим тендер зохион байгуулах журам, Засгийн газрын “Босго үнэ шинэчлэн батлах тухай 2013 оны 68 дугаар тогтоол”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

2019 онд худалдан авалт хийхдээ төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулах, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** ирүүлэхийг Захирал У.Санрайжав, Ерөнхий нягтлан бодогч Ц .Лхагвасүрэн нарт даалгав.

4. Бэлэн мөнгийг их хэмжээгээр харилцах данснаас чекээр гарган авч шууд худалдан авалт хийсэн, бэлэн мөнгөний зарцуулалтад хяналт тавиагүй, тооцоог сар бүр бодоогүй, эд хариуцагч тайлангаа гаргаж сураагүй байдлаас үүдэн мөнгөн кассаар ажиллаж байсан А.Мөнхтуяагийн нэр дээр 12,529,308.63 төгрөгийн, Б.Сарангоогийн нэр дээр 6,589,509,03 төгрөг нийт 19,118,817.66 төгрөгийг дараа тооцооны авлага бүртгэж, тооцоог бодоогүй байна.

Бэлэн мөнгөний тайлан тооцоог хариуцсан зарим нягтлан бодогч нар бараа материал худалдан авах ажиллагаа, бэлэн мөнгийг хүргэх, тоолох, хариуцан авч явах ажлуудад тодорхой төвшинд оролцсон байна.

Энэ нь НББ тухай хуулийн 13 дугаар зүйл. "Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.1.4. "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2."Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.6-д."эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Мөнгөн кассаар ажиллаж байсан А.Мөнхтуяагийн нэр дээр 12,529,308.63 төгрөгийн, Б.Сарангоогийн нэр дээр 6,589,509.03 төгрөг нийт 19,118,817.66 төгрөгийн дараа тооцооны авлагыг дахин тооцож мөнгөн хөрөнгийг зарцуулах ажил гүйлгээнд хамтран оролцоогүй санхүүгийн ажилтныг сонгон тооцоог бодуулж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** ирүүлэхийг Гүйцэтгэх захирал У.Санрайжав, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн нарт даалгав.

5. ТБОНӨХБАҮХАТХууль зөрчин шууд худалдан авалт хийж өмнөх жилд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, уг зөрчлийг дахин давтан гаргасан байна.

Тус байгууллага тайлант онд нийт 679,884.8 мянган төгрөгийг харилцах данснаас бэлнээр авч Эрээн хотоос бараа түүхий эд материалыг шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн байна.

Зарцуулсан бэлэн мөнгөний зарцуулалтаас нийт 26531.4 мянган төгрөг эрсдэлд орж өр дутагдал болж тодорхойгүй байдалд орсон, кассын үйл ажиллагааны журам байхгүй, мөнгөн хөрөнгө их хэмжээгээр касс дээр олон хоногоор хадгалагдаж байгаад хяналт хийдэггүй, бэлэн мөнгө хадгалах, хамгаалах аюулгүй ажиллагааны нөхцөл бүрдээгүй байна.

Кассын ажилтан, кассын тайланг хийж хэвшээгүй, хариуцсан нягтлан бодогч бэлэн мөнгөний ажил гүйлгээг санхүүгийн тайланд тусгахдаа буруу бичилт хийсэн, анхан шатны нотлох баримтад И баримт хавсаргаагүй, хүчин төгөлдөр бус баримтууд хавсаргасан байна.

Бэлэн мөнгөөр бараа бүтээгдэхүүн авахдаа үнийн судалгааг хийдэггүй, захиалгын хуудас тодорхой бичигдээгүй баталгаажуулаагүй, нэгжийн өртгийг хянах боломжгүй, солигдох бараа бүтээгдэхүүнд дахин хил гаалийн бүрдүүлэлт хийхэд татвар төлж илүү зардал гарах барааны өртгийг хий өсөх эрсдэлтэй байна.

Бэлэн мөнгөний худалдан авалттай уялдан, санхүү бүртгэлийн хяналтгүй байдал нэмэгдсэн, хууль журам зөрчигдсөн, мөнгөн хөрөнгө ашиглах завших боломжийг бүрдүүлсэн, ашиглахгүй бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн, орон нутгийн үйлдвэр эрхлэгчийг дэмжих боломж хязгаарлагдсан зэрэг олон сөрөг үр дагавар гарсан тул бэлэн мөнгөний кассын үйл ажиллагааг зогсоож жижиг мөнгөн санг ажиллуулж, бараа бүтээгдэхүүн худалдан авах үйл ажиллагааг хуульд нийцүүлэн гэрээ байгуулж, бэлэн бус шилжүүлгээр гүйцэтгэх шаардлагатай.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, НББ тухай хуулийн 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн төвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” заасан заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авах ажиллагааны тухай хууль зөрчин шууд худалдан авалт хийж өмнөх жилд төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, уг зөрчлийг дахин давтан гаргаж их хэмжээний бэлэн мөнгө дутагдсан, нягтлан бодогч нар санхүүгийн хяналт хийж чадахгүй байгаа тул бэлэн мөнгөний кассыг жижиг мөнгөн сангаар сольж бараа татан авалтыг хуулийн дагуу бэлэн бусаар төлбөр хийх ажлыг зохион байгуулж өмнөх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 25-ны дотор **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** ирүүлэхийг ,захирал У.Санрайжав Ерөнхий нягтлан бодогч Ц .Лхагвасүрэн нарт даалгав.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгийн элэгдлийг холбогдох эрх зүйн актад нийцүүлэн тооцоолсон эсэх, НБББББичгийн сайжруулалт, мөнгөн кассын үйл ажиллагааг зогсоосон эсэх

Гэрээгээр гүйцэтгэж тендерийн ажлуудын үр дүн, үр өгөөжийг тооцох, ажил гүйцэтгэсэн орлогыг дансанд төвлөрүүлэх

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Чандмань-Бадрал ОНӨХХК чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 19 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,062,225,7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,118,828,1 мянган төгрөг буюу 56602,4 мянган төгрөгөөр буюу 1,8 хувиар илүү зарцуулсан байгаа нь хяналт муугаас хэтрүүлэн зарцуулсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Чандмань-Бадрал ОНӨХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 70 хувьтай байна.

1. Бэлэн мөнгөний нярав нь мөнгөн хөрөнгийг бүртгэн авч хадаглах хамгаалах үүрэг бүхий эд хариуцагч эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох үүрэгтэй байх ба мөнгөн хөрөнгийг зарцуулах эрхгүй, бэлэн мөнгөн гүйлгээний тайланг батлагдсан зааврын дагуу үйлдэж байх.
2. НД тухай хууль Татварын хуулийн хэрэгжилтийг хангаж мөрдөж ажиллах
3. НББ бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулах нь зүйтэй гэсэн 3 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Чандмань-Бадрал ОНӨХХК 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Чандмань-Бадрал ОНӨХХК нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Удирдлагын дээд болон дотоод хяналт

Илрүүлэлт

Санхүү бүртгэлийн алба Дэд захирлаар удирдуулсан 18 хүний бүрэлдэхүүнтэй түүний дотор 6 нягтлан бодогчтой ажиллаж байгаа хэдий ч мөнгөн касс, бараа материал, хөрөнгийн бүртгэл хөтлөлт, худалдан авах ажиллагаанд хяналт тавих ажлыг орхигдуулсан, албаны ажилтнууд уялдаа холбоо муутай хангалтгүй ажилласан байна. Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заасан заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж

Ажилтнуудын жил үүргийн хуваарь, байгууллагын бүртгэл мэдээллийн системийг боловсронгуй болгох,

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

Төсвийн захирагчийн хариу

Эрсдэл

1. Санхүү бүртгэлээр тавих хяналт сулрана.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.2 БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Бараа материалын захиалгын хуудас иж бүрэн биш, худалдан авалтыг төлөвлөлтгүй гүйцэтгэж үр дүнг нь үнэлэн хяналт тавих үйл ажиллагаа огт байхгүй, худалдан авах ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулаагүй зэрэг нь компанийн өртөг нэмэгдүүлэх, ашигт ажиллагаа сулрах эрсдэл бий болгож байна. Материаллаг нөөцийн үлдэгдэл 48907,7 мянган төгрөгөөр буюу 35 хувиар нэмэгдсэн байна. Тухайн байгууллагын үл хөдлөх хөрөнгийн цахим тайланд үл хөдлөх хөрөнгийн татварын зардлыг 6015.5 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Санхүүгийн тайланд тусгагдсан барилга байгууламжийн бүрэлдэхүүнээс үзэхэд оны эхэн дэх 819893.8 төгрөгийн хөрөнгө нь Иргэний тухай хуулийн 84.3 заасны дагуу бүгд үл хөдлөх хөрөнгө тул тухайн тайлант жилийн татварын зардлыг 8198.9 мянган төгрөгөөр тайлагнах бөгөөд зөрүү 2183.4 төгрөг болно. Мөн санхүүгийн тайланд тусгагдсан татварын өглөг 9998,7 мянган төгрөгөөр зөрүүтэй, татвар НДШ-ийн авлага 21293,4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгагдсан байна.

Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" заасан заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Зөвлөмж

1. Материалын үлдэгдэлд шинжилгээ хийж шаардлагагүй, төлөвлөөгүй, чанар байдал зөрүүтэй материал худалдан авахгүй байх
2. Татвартай холбоотой өглөг авлага үүсэн тухай бүрт нь тооцооллыг нягтлан шалгаж зөрүүгүй тайлагнах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Тайлант онд НБББББаримтгүй ажилласан байна. 2019 оны эхээр Боловсруулсан бодлогын баримт бичиг хэт хураангуй, ойлгомжтой тайлбар хийгдээгүй байна. Тайлант хугацаанд нийт 238 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд 137832.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна. 2018 оны 7 дугаар сараас эхэлж Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны №40 дүгээр тогтоолыг үндэслэн элэгдэл тооцох байсан боловч мөрдөж ажиллаагүй байна

Энэ нь хэмжилт, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.2- д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" заасан заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Эрсдэл

3. Санхүү бүртгэлээр тавих хяналт сулрана.

Зөвлөмж

1. НБББББ-ийг сайжруулан дахин боловсруулах.
2. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зохих дүрэм, журмын дагуу тооцоолох.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.4 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

Тус байгууллага сар бүр үр дүнгийн урамшуулал 30%, зэргийн нэмэгдэл, удаан жилийн нэмэгдэл зэргийг үндсэн цалин дээр тооцоолж олгож байна. Захирлын 2018-07-03-ны өдрийн А/50 тоот тушаалаар ажилчдад шагналт цалин 30%-иар нэмж олгосон нь тушаалын үндэслэл болгосон хурлын тэмдэглэл байхгүй, ажилчид албан хаагчдын ажлын үр дүнг хэрхэн тооцсон нь тодорхой бус байгаа тул тус нэмэгдлийг хүчин төгөлдөр бус шийдвэрээр олгосон байна.

Энэ нь хэмжилт, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна. заасан заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Эрсдэл

2. Цалин хөлс урамшуулал илүү дутуу тооцох

Зөвлөмж

1. Аливаа нэмэгдэл урамшууллыг олгохдоо үндэслэсэн эрх зүйн акт, хурлын шийдвэр, тушаал зэрэг хүчин төгөлдөр баримтаар баталгаажуулах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.5 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

Илрүүлэлт

Харилцагчдын зарим мэдээлэлд ,ID кодыг бүх баримтууд дээр бичих, хаягийг нэгдсэн нэг нэршлээр бичээгүй өөр нэршлээр бичсэн, байрны талбайн хэмжээний нэгдсэн дүнг тайлангуудад өөр дүнгээр оруулсан байна.

Энэ нь хэмжилт, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Эрсдэл

2. Харилцагчдын авлага өглөг буруу тооцох эрсдэлтэй

Зөвлөмж

1. Харилцагч бүрээр нэгдсэн нэг ID код боловсруулан мөрдөж ажиллах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.6 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

Илрүүлэлт

Үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байгаа нь хөрөнгө үнэгүйдэх, ашиглалт, хадгалалт хамгаалалт сулрах, хөрөнгийн буруу ангилж бүртгэсэн нь тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийг бодитой хүртэх боломжгүй болгож байна. Энэ үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал дутуу тооцоологдох эрсдэлийг бий болгож байна, Тендерт оролцож авсан шугам засварын гэрээт ажил дуусан боловч ажил хүлээлцээгүй, акт үйлдээгүй, гүйцэтгэсэн ажлын санхүүжилт, холбогдох мэдээлэл тайлан, ажлын үр дүн, байгууллагад орж ирэх санхүүжилт орж ирээгүй, туслан гүйцэтгэсэн компани нэр дээр өр үүссэн байна.

Энэ нь хэмжилт, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2018 оны №40 дүгээр тогтоолын хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Эрсдэл

1. Хөрөнгийн хадгалалт хамгаалалт сулрах
2. Гүйцэтгэсэн ажлын үр дүн тодорхойгүй болох

Зөвлөмж

1. Хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулах
2. Тендерийн ажлын үр дүнг үнэлэх, хяналтын тогтолцоог сайжруулах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.7 Дотоод аудит

Илрүүлэлт

Нийт арилжааны банканд 11 харилцах болон хадагламжийн данстай 11 дугаар сарын 31-ны байдлаар 596311,5 мянган төгрөгийн үлдэгдэлтэйг баталгаажуулсан байна. Капитрон банкинд цахим тендертэй холбоотой 4732,0 мянган төгрөг байршуулсан орлогын ганцхан гүйлгээтэй, 3 банкны дансаар огт гүйлгээ хийгдээгүй. Голомт банкны долларын болон төгрөгийн данс, ХААН банк төгрөгийн данс, Капитрон банканд 10000,0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй 1 гүйлгээ хийгдсэн. 2018 оны 7 сараас Голомт банканд юаны харилцах данс нээж ашиглаж эхэлсэн, Бусад 5 дансанд орлого болон зарлагын гүйлгээ тогтмол хийгдсэн байна. Хэт олон данс хяналт алдах эрсдэлтэй байна.

Энэ нь хэмжилт, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Эрсдэл

1. Олон данснаас гүйлгээ гаргаж хяналт сулрана.

Зөвлөмж

1. Харилцах дансны 5 дансаар орлогыг хуримтлуулж зарлагын гүйлгээг 1 дансаар хийх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Замын-үүд сумын Чандмань-Бадрал ОНӨХХК Гүйцэтгэх Захирал У.Санрайжав, Дэд захирал Ц.Баасандорж, Ерөнхий нягтлан бодогч Ц.Лхагвасүрэн

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Ч.АРИУНАА	Огноо:
--------------------------	-----------	--------

АУДИТЫН МЕНЕЖЕР	Ц.ЛҮНДЭГМАА	Огноо:
-----------------	-------------	--------

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР	Б.БАЙГАЛ	Огноо:
---------	----------	--------

Чандманьбадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018.12.31

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018 оны 01-р сарын 01	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	596,667,870.69	603,673,872.99
1.1.2	Дансны авлага	230,781,929.00	553,904,213.61
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	4,774,884.85	18,790,545.47
1.1.4	Бусад авлага	15,723,683.21	20,340,286.97
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	141,140,168.69	198,801,648.31
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	0.00	6,372,430.85
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	989,088,536.44	1,401,882,998.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	737,590,292.00	1,710,691,306.94
1.2.2	Биет бус хөрөнгө	9,370,802.31	6,341,249.05
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	746,961,094.31	1,717,032,555.99
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,736,049,630.75	3,118,915,554.19
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	20,911,125.24	133,935,100.79
2.1.1.3	Татварын өр	34,549,170.77	69,467,190.94
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,088,776.34	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	64,542,536.51	71,763,684.40
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	0.00	3,238,927.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	121,091,608.86	278,404,903.13
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.5		0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	121,091,608.86	278,404,903.13
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	846,529,959.90	846,529,959.90
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	754,554,116.80
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	.	0.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	0.00	161,850,999.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	768,428,061.99	1,077,575,574.76
	Тайлангийн үеийн ашиг	0.00	324,492,654.33
2.3.10	Өмнөх үеийн ашиг	768,428,061.99	753,082,920.43
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,614,958,021.89	2,840,510,651.06
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	1,736,049,630.75	3,118,915,554.19

Чандманьбадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2018.12.31
/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	3,599,494,557.86
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	3,094,563,693.10
3	Нийт ашиг (алдагдал)	0.00	504,930,864.76
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	27,052,107.61
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
08.1	Орлогын дүн	0.00	27,052,107.61
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	0.00	169,997,531.04
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	425,388.75
12.1	Зардлын дүн	0.00	170,422,919.79
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	30,790.14
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	909,090.91
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	-1,757,285.94
17.1	Олз гарзын дүн	0.00	-817,404.89
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0.00	360,742,647.69
19	Орлогын татварын зардал	0.00	36,249,993.36
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0.00	324,492,654.33
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	0.00	324,492,654.33
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Чандманьбадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2018.12.31
/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	3,887,968,018.49
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	3,603,562,679.14
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	0.00	284,405,339.35
1.2	Мөнгөн зарлага (-)	0.00	3,914,171,357.24
	Ажиллагчдад төлсөн	0.00	1,017,608,336.43
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	0.00	314,641,506.15
	Бараа материал худалдан авахад төлсөн	0.00	1,239,050,034.55
	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	188,966,009.61
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	335,794,256.51
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	0.00	405,405,112.80
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	2,569,536.00
	Бусад мөнгөн зарлага	0.00	410,136,565.19
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(26,203,338.75)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	33,209,341.05
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	1,000,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	32,209,341.05
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	33,209,341.05
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.00	7,006,002.30
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	596,667,870.69
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	603,673,872.99

Чандманьбадрал ОНӨХХК 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018.12.31
/Төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2016 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	-	-	-	-	-
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт		-	-		-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	-	-
2017 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	846,529,959.90	-	-	768,428,061.99	1,614,958,021.89
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-	(15,345,141.56)	(15,345,141.56)
Залруулсан үлдэгдэл	846,529,959.90	-	-	753,082,920.43	1,599,612,880.33
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	324,492,654.33	324,492,654.33
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт		-	161,850,999.60	-	161,850,999.60
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	754,554,116.80	-	-	754,554,116.80
2018 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	846,529,959.90	754,554,116.80	161,850,999.60	1,077,575,574.76	2,840,510,651.06